

# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГСА-2024/60/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Говьсүмбэр аймаг 2024 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179, Цахим хаяг: <a href="mailto:sarantuyab@audit.gov.mn">sarantuyab@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: <a href="mailto:naranbayarg@audit.gov.mn">naranbayarg@audit.gov.mn</a></p> <p>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: "Платиниум прогресс аудит" ХХК Захирал: Ж.Баяртуул Утас: 99066015, Цахим хаяг: <a href="mailto:platinumprogressaudit@gmail.com">platinumprogressaudit@gmail.com</a></p> <p>Аудитор: Г.Гантуяа Утас: 99060147, Цахим хаяг: <a href="mailto:platinumprogressaudit@gmail.com">platinumprogressaudit@gmail.com</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: goviusumber@audit.gov.mn

2024.02.22 № 12

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

008020287

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 81.0 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>102,893,244.92</u></b>	<b><u>201,361,520.56</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	13,545,360.72	87,463,935.36
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	13,545,360.72	87,463,935.36
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	13,545,360.72	87,463,935.36
31211	Төрийн сангийн харилцах	13,545,360.72	87,463,935.36
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	89,347,884.20	113,897,585.20
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	106,000.00	143,000.00
35130	Эм боох материал	106,000.00	143,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	89,241,884.20	113,754,585.20
35410	Бичиг хэргийн материал	442,400.00	123,200.00
35420	Аж ахуйн материал	730,900.00	25,000.00
35460	Хүнсний материал	2,516,795.40	4,731,210.40
35470	Бусад хангамжийн материал	85,551,788.80	108,875,174.80
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>687,702,188.57</u></b>	<b><u>662,613,924.95</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	687,702,188.57	662,613,924.95
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	665,526,688.41	640,682,424.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	787,600,000.00	787,600,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(148,230,000.00)	(189,240,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	35,511,020.00	53,470,807.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(17,463,699.54)	(16,883,888.81)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,022,272.00	19,160,682.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,912,904.05)	(13,425,175.24)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	22,175,500.16	21,931,500.00
39301	Програм хангамж	1,220,000.00	1,220,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(968,499.84)	(1,212,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	21,924,000.00	21,924,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>790,595,433.49</u></b>	<b><u>863,975,445.51</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	=	<b><u>791,701.19</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	791,701.19
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	791,701.19
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	327,011.19
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	464,690.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	464,690.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>790,595,433.49</u></b>	<b><u>863,183,744.32</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	790,595,433.49	863,183,744.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	21,924,000.00	21,924,000.00
51101	Өмч: - төрийн	21,924,000.00	21,924,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	768,671,433.49	841,259,744.32
51210	Өмнөх үеийн үр дүн	768,671,433.49	768,671,433.49

51220	Тайлант үеийн үр дүн	-	72,588,310.83
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>790,595,433.49</u></b>	<b><u>863,975,445.51</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,288,876,332.57</b>	<b>725,785,100.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>828,336,632.57</b>	<b>45,986,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	828,336,632.57	45,916,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	828,336,632.57	45,916,500.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	737,433,226.37	28,716,500.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	90,903,406.20	17,200,000.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	-	70,000.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	-	70,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>460,539,700.00</b>	<b>679,798,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	392,948,100.00	631,588,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	392,948,100.00	631,588,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	103,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500.00	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	67,488,100.00	48,210,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,488,100.00	48,210,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>498,280,899.08</b>	<b>647,703,450.96</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>498,280,899.08</b>	<b>647,703,450.96</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	493,015,078.04	643,145,851.50
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	286,925,997.28	408,535,294.47
210101	Үндсэн цалин	286,925,997.28	238,675,405.10
210102	Нэмэгдэл	-	135,553,823.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	14,331,994.84
210104	Урамшуулал	-	19,974,070.56
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	36,496,922.00	51,843,861.43
210201	Тэтгэврийн даатгал	25,031,318.00	34,259,606.30
210202	Тэтгэмжийн даатгал	2,944,862.00	4,372,892.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,332,367.00	3,066,042.70
210204	Ажилгүйдлийн даатгал	562,500.00	920,616.90
210205	Эрүүл мэндийн даатгал	5,625,875.00	9,224,702.72
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	38,165,247.96	42,237,011.19
210301	Гэрэл, цахилгаан	3,969,171.96	6,577,660.09
210302	Түлш, халаалт	31,860,225.00	31,999,607.10
210303	Цэвэр, бохир ус	2,335,851.00	3,659,744.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,503,947.00	3,413,524.00

210401	Бичиг хэрэг	2,031,400.00	-
210402	Тээвэр, шатахуун	660,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,545,700.00	-
210408	Бараа материал акталсны зардал	5,266,847.00	3,413,524.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>61,036,326.00</b>	<b>62,754,005.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	226,500.00	-
210502	Хоол, хүнс	60,809,826.00	62,754,005.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>-</b>	<b>6,300,000.00</b>
210604	Урсгал засвар	-	6,300,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>812,000.00</b>	<b>2,025,800.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,512,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	812,000.00	513,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>55,074,637.80</b>	<b>66,036,355.41</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,238,600.00	12,431,980.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	105,000.00	3,950,050.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49,731,037.80	49,654,325.41
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,265,821.04</b>	<b>4,557,599.46</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>4,557,599.46</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	4,557,599.46
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>5,265,821.04</b>	<b>-</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,265,821.04	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>790,595,433.49</u></b>	<b><u>78,081,649.04</u></b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>5,493,338.21</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	5,493,338.21
<b>5</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>790,595,433.49</u></b>	<b><u>72,588,310.83</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>460,539,700.00</u></b>	<b><u>679,868,600.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>-</b>	<b>70,000.00</b>
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>70,000.00</b>
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	-	70,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>460,539,700.00</b>	<b>679,798,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>392,948,100.00</b>	<b>631,588,600.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	392,948,100.00	631,588,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>103,500.00</b>	<b>-</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500.00	-

<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	67,488,100.00	48,210,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,488,100.00	48,210,000.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	-	-
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	-	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>446,994,339.28</u></b>	<b><u>605,950,025.36</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>446,994,339.28</b>	<b>605,950,025.36</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>441,728,518.24</b>	<b>601,392,425.90</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	279,232,678.17	408,535,294.84
210101	Үндсэн цалин	224,556,812.40	238,675,405.10
210102	Нэмэгдэл	40,402,004.00	135,553,824.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,088,000.00	14,331,994.84
210104	Урамшуулал	8,185,861.77	19,974,070.56
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	44,190,241.11	51,843,861.06
210201	Тэтгэврийн даатгал	28,653,242.00	34,259,606.30
210202	Тэтгэмжийн даатгал	3,518,286.23	4,372,892.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,590,970.12	3,066,042.70
210204	Ажилгүйдлийн даатгал	3,415,178.75	920,616.90
210205	Эрүүл мэндийн даатгал	6,012,564.01	9,224,702.35
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	38,661,747.96	41,910,000.00
210301	Гэрэл, цахилгаан	3,969,171.96	6,250,648.90
210302	Түлш, халаалт	32,356,725.00	31,999,607.10
210303	Цэвэр, бохир ус	2,335,851.00	3,659,744.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	103,500.00	-
210401	Бичиг хэрэг	103,500.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	58,658,951.00	64,968,420.00
210502	Хоол, хүнс	58,658,951.00	64,968,420.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,412,000.00	6,300,000.00
210604	Урсгал засвар	7,412,000.00	6,300,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	812,000.00	1,313,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	812,000.00	1,313,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	12,657,400.00	26,521,050.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,597,400.00	22,317,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,060,000.00	4,204,050.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,265,821.04</b>	<b>4,557,599.46</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	4,557,599.46
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	4,557,599.46
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	5,265,821.04	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,265,821.04	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>13,545,360.72</u></b>	<b><u>73,918,574.64</u></b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	-

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		≡	≡
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		≡	≡
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	13,545,360.72		73,918,574.64
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	13,545,360.72
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,545,360.72		87,463,935.36

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,924,000.00	-21,924,000.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
3	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>21,924,000.00</b>	<b>-21,924,000.00</b>	0.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00
7	Тайлант үеийн үр дүн	0.00	790,595,433.49	790,595,433.49
8	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>21,924,000.00</b>	<b>768,671,433.49</b>	790,595,433.49
9	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>21,924,000.00</b>	<b>768,671,433.49</b>	<b>790,595,433.49</b>
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
11	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>21,924,000.00</b>	<b>768,671,433.49</b>	790,595,433.49
12	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00
13	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00
14	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00
15	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			0.00
16	Тайлант үеийн үр дүн	0.00	72,588,310.83	72,588,310.83
17	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>21,924,000.00</b>	<b>841,259,744.32</b>	<b>863,183,744.32</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	693,413,700.00	605,950,025.36
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	693,413,700.00	605,950,025.36
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	688,856,100.00	601,392,425.90
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	471,107,700.00	408,535,294.84
210101	Үндсэн цалин	324,826,400.00	238,675,405.10
210102	Нэмэгдэл	136,654,500.00	135,553,824.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	14,331,994.84
210104	Урамшуулал	9,626,800.00	19,974,070.56
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	58,889,300.00	51,843,861.06
210201	Тэтгэврийн даатгал	40,044,500.00	34,259,606.30
210202	Тэтгэмжийн даатгал	4,711,000.00	4,372,892.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,769,100.00	3,066,042.70
210204	Ажилгүйдлийн даатгал	942,300.00	920,616.90
210205	Эрүүл мэндийн даатгал	9,422,400.00	9,224,702.35
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	41,910,000.00	41,910,000.00
210301	Гэрэл, цахилгаан	6,200,000.00	6,250,648.90
210302	Түлш, халаалт	31,710,000.00	31,999,607.10
210303	Цэвэр, бохир ус	4,000,000.00	3,659,744.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	-	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	82,303,600.00	64,968,420.00
210502	Хоол, хүнс	82,303,600.00	64,968,420.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,300,000.00	6,300,000.00
210604	Урсгал засвар	6,300,000.00	6,300,000.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	-	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,402,300.00	1,313,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,402,300.00	1,313,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	26,943,200.00	26,521,050.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,736,200.00	22,317,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,207,000.00	4,204,050.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	4,557,600.00	4,557,599.46
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,557,600.00	4,557,599.46
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,557,600.00	4,557,599.46
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	-
<b>2260</b>	<b>Гадаад эх үүсвэрээр</b>	-	-
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	-	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	679,798,600.00	679,798,600.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	631,588,600.00	631,588,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	631,588,600.00	631,588,600.00

1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	48,210,000.00	48,210,000.00
122005	Орон нутгийн төсвөөс	48,210,000.00	48,210,000.00
1340	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	-
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	-
122	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	-	-
14	<b>БУСАД ЭХ ҮҮСВЭР</b>	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	13,545,360.72
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	87,463,935.36

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1,342.9 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

- Тайлант оны үр дүнгийн тайлангийн зардлын дүн мөнгөн гүйлгээний зардлын дүнгийн уялдааг шалгахад 1,342.9 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.

Аудитаар нийт 2,744.1 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 2,744.1 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоов.

## 5.1 Төлбөрийн акт

**5.1.1** Нягтлан бодогчийн ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр олгосон боловч цэцэрлэгийн эрхлэгчийн 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн Б/15 дугаар тушаалаар санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Зөрчилгүй" дүгнүүлсэн гэх үндэслэлээр 1,292.2 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51.1.4 дэх “ Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3: “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна”, Сангийн сайдын 2022 оны 28 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 25 дахь заалт гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба “Үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон урамшууллыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**5.1.2** Зургаан ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй 1,004.9 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 99.1 "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон цалинг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.



Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Байхгүй								
Дүн								
Хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Нэг албан хаагчид илүү цагийн хөлсийг илүү тооцож олгосон	1	0.4	1	0.4				
Дүн	1	0.4	1	0.4				
Нийт дүн	1	0.4	1	0.4				

